# Contents

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ..... 3

2. ТӨСЛИЙН ҮНДСЭН БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ ..... 6

3. ПАБЛИК СЕРВИС ХХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ҮНДСЭН ҮР ДҮН ..... 8

4. СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 9

4.2.1. Ус хэмнэх талаарх мэдээлэл ..... 12

4.2.2. Ус түлгээх худгийн хяналт ..... 12

4.3.2. Хог хаягдлын тээвэрлэлт ..... 15

5. НӨХӨН СЭРГЭЭЛТ НОГООН БАЙГУУЛАМЖ ..... 20

6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ..... 23

6.1.2 Зам талбайд хийсч тарсан хог хаягдлын цэвэрлэгээ зохион байгуулах ..... 23

7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 24

8. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 25

9. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 27

9.1 Зам талбайд хийсч тарсан хог хаягдлын цэвэрлэгээ зохион байгуулах ..... 30

9.3 Хаягдал тосыг цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх ..... 30

10.4 Аюултай хог хаягдлын зохицуулалт ..... 31

Аюултай хог хаягдал болох хаягдал өдрийн гэрлыг эрх бүхий компанид хүргүүлэх ..... 33

11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... 35

12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ ..... 39

**12.2.3. Гадаад орчны агаарын чанарын хяналт шинжилгээ** ..... 44

13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ ..... 44

14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТӨСВИЙН ЗАДАРГАА....................................................................................................48

## 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Паблик Сервис” ХХК нь “Энержи Ресурс” ХХК-ийн “Ухаа худаг” нүүрсний уурхайн зөвшөөрөгдсөн 6116 м.кв талбайд уурхайн бүсээс гарч буй 10 нэр төрлийн аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, түр хадгалах үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд жилд 4000-5000 м.куб аюултай хог хаягдлыг татан зайлуулдаг. Төсөл хэрэгжүүлэгч нь уурхайн засварын төв, дэд бүтцийн бусад барилга байгууламж, үйл ажиллгаанаас гарах хог хаягдлыг цуглуулах, ангилан ялгах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа хариуцан хэрэгжүүлдэг.

Паблик Сервис компани нь 2009 онд Ухаа худаг уурхайн төслийн талбайгаас гарч буй хог хаягдлын менежментийг холбогдох хууль журамд нийцүүлэн хэрэгжүүлэх зорилготойгоор Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт үүсгэн байгуулагдсан.

Манай компани нь 2009 онд 5 ажилтантай үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол 2023 оны байдлаар тогтмол 28 ажилтан, хог тээврийн гурван машин, ажилчдын нийтийн тээвэр нэг, ажиллагсдын өдрийн гал тогоо, оффис, дахиварын цех зэрэг хог хаягдлын үйл ажиллагааг цогцоор нь эрхлэх хүчин чадал, нөөцтэй болж үйл ажиллагаагаа тасралтгүй тогтмол явуулж байна.



*Зураг 1.1. Дахиврын цех*

Хүснэгт 1.1. Хог хаягдал ангилан ялгах болон дахиврын цехийн координат

| д/д | Өргөрөг | Уртраг |
|---|---|---|
| 1. | 43 41 39.4 | 105 32 23.8 |
| 2. | 43 41 40.1 | 105 32 25.7 |
| 3. | 43 41 38.7 | 105 32 26.7 |
| 4. | 43 41 38.0 | 105 32 24.9 |
| 5. | 43 41 37.4 | 105 32 21.6 |
| 6. | 43 41 39.1 | 105 32 20.9 |
| 7. | 43 41 39.4 | 105 32 22.9 |
| 8. | 43 41 39.5 | 105 32 23.7 |

Тус талбайг Газрын тухай хуулийн 35-р зүйлийн 35.1.6 дахь заалт, Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газрын даргын 2008 оны 83-р тушаалыг үндэслэн Сумын засаг даргын 2020 оны 4-р сарын 28-ний өдрийн А/102 дугаартай захирамжаар 4604000328 нэгж талбарын дугаартай, Ухаахудаг уурхайн ард талд байршилтай, барилга байгууламжийн зориулалт бүхий Энержи Ресурс ХХК-ийн эзэмшил газраас 0.611 га газрыг аюултай хог хаягдлыг дахин боловсруулах, ангилан ялгах цехийн зориулалтаар компани хоорондын гэрээний дагуу ашиглаж байна.

## 1.1 Үндсэн үйл ажиллагаа

"Паблик Сервис" ХХК нь Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх түр зөвшөөрлийг Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас 2022 оны 4-р сарын 28-ны өдөр гэрчилгээжүүлж авсан ба 2023 оны 5-р сарын 22-ны өдөр дахин 2 жилийн хугацаатайгаар сунгасан байна.


АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, УСТГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТҮР ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар 0000009 Огноо: 2022.04.28

Хог хаягдлын тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг үндэслэн аюултай хог хаягдал Аюултай хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах (зөвшөөрлийн төрөл) үйл ажиллагаа эрхлэх түр зөвшөөрлийг 1111003063 улсын бүртгэлийн дугаартай 3614263 регистрийн дугаартай ПАБЛИК СЕРВИС ХХК-д 2022 оны 04 сарын 28-ны өдрөөс олгов.

**Үйл ажиллагаа эрхлэх талаарх мэдээлэл:**

Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгчдийн бүртгэлийн дугаар 0000009

Аж ахуйн нэгж/иргэний хаяг: Өмнөговь аймаг, хот Цогтцэций сум, дүүргийн Цогтцэций баг баг, хорооны Ухаа худаг-0 (гудамж, байшин/хашааны дугаар)

Зөвшөөрөл олгосон үйл ажиллагаа явуулах газрын байршил:
аймаг, хот ____ сум, дүүргийн ____
баг, хорооны ____ (газрын нэр/гудамжны нэр, дугаар)

**Энэхүү зөвшөөрөл нь барилгын ажил эхлэхээс үйл ажиллагаа эхлүүлэх хүртэлх хугацаанд хүчинтэй.**

**Зөвшөөрөл олгосон:**

Энэхүү зөвшөөрлийг Хог хаягдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.2 дахь заалт-ыг үндэслэн:

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД (байгууллагын нэр, албан тушаал) (гарын үсэг, тамга) Б.БАТ-ЭРДЭНЭ (овог нэр)


2023 оны 05 сарын 22 өдрийн 0000009 зөвшөөрлийн 1 хавсралт

| № | Тушаалын дугаар | Хугацаа | Олгосон өдөр |
|---|---|---|---|
| 1 | А/175 | 2023.05.22-2024.05.22 | 2023.05.22 |
| 2 | А/175 | 2024.05.22-2025.05.22 | 2023.05.22 |
| 3 | | | |
| 4 | | | |
| 5 | | | |

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД Б БАТ-ЭРДЭНЭ

**САНАМЖ:**
Тус яамнаас олгосон энэхүү гэрчилгээг зориулалтын бусаар ашигласан, үйл ажиллагаандаа ноцтой алдаа дутагдал гаргасан, худалдан борлуулсан, холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн бол хүчингүй болох үндэслэл болно.

*Зураг 2.2. Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх түр зөвшөөрөл*

### 1.2 Төсөл хэрэгжиж байгаа газар нутгийн байгаль орчны төлөв байдал

**Хүн ам, эдийн засаг, зам харилцаа***:* Цогтцэций сум нь 72.5 хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэртэй, нийслэлээс 540 км , аймгийн төвөөс 100 км зайд, Цогт-Овоо, Манлай, Баян-Овоо, Ханхонгор, Ханбогд, Номгон сумдтай, Дундговь аймгийн Өлзийт сумтай хиллэн, далайн түвшингээс дээш 1200-1791 м-ийн өндөрлөгт орших бөгөөд бүхэлдээ говь цөлийн бүсэд хамаарна. Цогтцэций суманд Сийрст, Билгэх, Цагаан-Овоо, Өгөөмөр гэсэн 4 багийн нийт 1766 өрхөд 5180 хүн амьдардаг. Уул уурхайд ажилладаг 19 мянган орчим түр оршин суугчтай.Хүн амын тоогоор Өмнөговь аймгийн 15 сумаас 1-т, газар нутгийн хэмжээгээр 11-д ордог. Аймгийн төвийг оролцуулалгүйгээр хүн амын нягтралаар 5.49 хүн/га сум юм.




Төсөл хэрэгжиж буй бүс нутаг нь байгалийн мужлалаар Говийн их мужийн бор хөрсний бүсэд багтах ба газрын гадарга, газарзүйн хувьд нам уулс ухаа гүвээ толгодод хамрагдана. Хөрсний хээрийн судалгаа ба лабароторийн шинжилгээний үр дүнд үндэслэж доор дурьдсан хөрсний хэв шинж, дэд хэв шинж, төрөл, зүйлийг тогтоосон. Үүнд:

- Нам уулс, ухаа гүвээ толгодын сул хөгжилтэй чулуутай бор хөрс
- Цөлөрхөг хээрийн тал хөндийн үүрмэг чулуутай бор хөрс
- Цөлөрхөг хээрийн тал хөндийн чулуутай бор хөрс
- Цөлөрхөг хээрийн нугархаг хөрс
- Гуу жалга сайрын хөрс

#### 1.2.2. Уур амьсгалын тойм

Даланзадгад хотын сүүлийн 10 жилийн агаарын температурын мэдээнээс харахад жилийн агаарын дундаж температур нь 5.8$^0$С байна. Цогтцэций сумын жилийн агаарын дундаж температур 4.3$^0$С байдаг байна. Жилийн хамгийн хүйтэн сар нь 1 дүгээр сар буюу дундаж агаарын температур нь 12.9 - -13.7$^0$С, хамгийн дулаан сар нь 7 дугаар сар буюу дундаж агаарын температур нь +23.1 - +24.5$^0$С байдаг байна. Уур амьсгалын дулаарлаас болж жилийн хүйтэн үеийн үргэлжлэх хугацаа, хүйтний нөөц багасч, дулаан үеийн үргэлжлэх хугацаа уртасч дулааны нөөц нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

Энэ бүс нутагт жилдээ 104.3 мм орчим хур тунадас унадаг. Хур тунадасны хэмжээ жилийн дотор нилээд өөрчлөлттэй хуваарилагддаг буюу 4-10 дугаар сарууудад жилийн нийт хур тунадасны 6893% нь унадаг боловч зөвхөн 7-8 дугаар сарууудад 60-70% орчим нь унадаг байна. Сүүлийн жилүүдэд уур амьсгалын дулаарлаас шалтгаалан зүсрэн орох бороо цөөрч гол төлөв хүчтэй аадар бороны тоо олшрох болсон. Жилийн дундаж салхины хурд 2.4-5.1 м/сек ба сүүлийн 10 жилд салхины хурд хамгийн ихдээ 30 м/сек хүрч ширүүсч байсан байна. Төслийн бүс нутагт хаврын улиралд салхины хурд харьцангуй их буюу 4.3-5.1 м/сек хурдтай байдаг. Өвлийн улиралд баруун, баруун хойд, хойд чиглэлийн салхи зонхилж байснаа зуны улиралд өмнөд зүгийн салхины давтагдал нэмэгдэж ирдэг зүй тогтолтой. Агаарын харьцангуй чийгшлийн их утга нь өвлийн сарууудад ажиглагдах бөгөөд 1 ба 12 дугаар сарууудад 50-68% байна. Хавар намарт агаарын харьцангуй чийгшлийн бага утга буюу 22-47% ажиглагдана.

## 2. ТӨСЛИЙН ҮНДСЭН БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Паблик сервис ХХК-ийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, ангилан ялгах, дахин ашиглах үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг тус компанийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний судалгаагаар тодорхойлсон байдаг. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, ангилан ялгах, дахин ашиглах үйл ажиллагаанаас гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг түүнд өртөх орчноор нь буюу агаар, гадаргын болон газар доорх ус, хөрс, амьтан ургамлын аймгийг хамруулан дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

### 2.1. Агаарын чанарт үзүүлэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

**Үндсэн сөрөг нөлөөллүүд:**

- Хог хаягдлын тээвэрлэлтээс агаарт тоосонцорын хэмжээ ихсэх
- Хог хаягдалд агуулагдах тосолгооны материал, химийн бодисын үлдэгдлээс агаар орчинд бохирдол үүсэх,
- Хог хаягдлын турбо бурнер зуухны филтер бохирдсоноор агаарт хорт хий ялгарах;

**Болзошгүй сөрөг нөлөөллүүд:**

- Хог хаягдлын ангилан ялгах хэсэгт гал түймрийн болзошгүй эрсдэл үүсэх
- Төслийн хэмжээнд ашиглаж байгаа хатуу хучилттай зам эвдрэх, зам засах зэргээс шалтгаалан шороон зам гарган ашигласнаас агаарт тоосжилт үүсэх
- Дахиврын цехэд хог хаягдлыг дахин боловсруулах үйл явцад гагнуур ашигласнаар агаарт хорт хий ялгарах;

### 2.2. Усны чанарт үзүүлэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

**Үндсэн сөрөг нөлөөлөл:**

- Аюултай хог хаягдал хадгалах талбай хур тунадсы нөлөөгөөр угаагдалд орж бохирдол тархах.

**Болзошгүй сөрөг нөлөөлөл:**

- Хаягдал тос юүлэх тээвэрлэх үед нефтийн бүтээгдэхүүн алдагдаж хөрс усыг бохирдуулах.
- Бохир усны шугам халих, эвдрэл үүссэнээр хөрс бохирдох, хөрсний бохирдлоор дамжин ус бохирдох;

### 2.3. Хөрсний чанарт үзүүлэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

**Үндсэн сөрөг нөлөөлөл:**

- Хог хаягдлыг цуглуулах ангилан ялгах талбайгаас хэтрүүлэн хурааснаар хөрс бохирдох
- Тос тосолгооны материалаас хөрс бохирдох

**Болзошгүй сөрөг нөлөөлөл:**

- Салаа зам үүсгэснээс шалтгаалан хөрс эдэгдэл эвдрэлд орох.
- Тос тосолгооны материал, бохир ус асгарснаас шалтгаалан хөрс бохирдох.
- Хатуу хог хаягдлыг зөвшөөрөлгүй газар хаяснаар хөрс бохирдох.

### 2.4. Ургамлан бүрхэвчид үзүүлэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллүүд

**Үндсэн сөрөг нөлөөлөл:**

- Тээвэрлэлтийн үед ургамлан бүрхэвч устах.
- Шинээр барилга байгууламж барих, зам гаргах зэргээс хөрсөн бүрхэвч эвдрэл элэгдэлд орж тухайн хэсгийн ургамлан бүрхэвч доройтох.

**Болзошгүй сөрөг нөлөөлөл:**

- Салаа зам үүсгэснээс шалгаалан хөрс эдэгдэл эвдрэлд орж ургамлан бүрхэвчид нөлөөлөх.
- Тос тосолгооны материал, бохир ус асгарсанаас шалтгаалан ургамлын ургалтанд нөлөөлөх.

**2.5. Биологийн төрөл зүйлд үзүүлэх үндсэн болон болзошгүй сөрөг нөлөөллүүд**

**Үндсэн сөрөг нөлөөлөл:**

- Хог хаягдлын хяналтгүй тархалтаас шалтгаалан амьтны амьдрах орчинд нөлөө үзүүлэх;
- Хог хаягдлаар амьтад хооллох, орооцолдох зэргээс эрсдэл үүсэх;

**Болзошгүй сөрөг нөлөөлөл:**

- Тээврийн зам хөндлөн гарах амьтад машинд дайруулах.

## 3. ПАБЛИК СЕРВИС ХХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ, ҮНДСЭН ҮР ДҮН

Өмнөговь аймгийн Цогтцэций суманд орших Паблик сервис ХХК-ийн Байгаль орчны менежмент төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг боловсруулахдаа БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10 сарын 29-ны өдрийн А-618 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежмент төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ыг баримталсан бөгөөд тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын биелэлтийн байдлыг нэг бүрчлэн тодорхойлж, шаардагдсан хөрөнгө зардлыг тооцсон бөгөөд орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн биелэлтийн хэсэгт хяналт шинжилгээний ажлын үр дүнг дэлгэрэнгүй хэлбэрээр тусгасан болно.

Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд түүний биелэлтийн тоон үзүүлэлтийг дараах хүснэгтэнд нэгтгэн илэрхийлэв.

*Хүснэгт 2. Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын хэрэгжилт*

| д\д | Байгаль орчны хамгаалах арга хэмжээний төрөл | Төлөвлөсөн ажлын тоо | Гүйцэтгэсэн ажлын тоо | Хийгдэж буй болон хойшлогдсон ажлын тоо |
|---|---|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ | 14 | 13 | 1 |
| 2 | Нөхөн сэргээлт | 2 | 2 | 0 |
| 3 | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ | 2 | 2 | 0 |
| 4 | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө | 1 | 1 | 0 |
| 5 | Хог хаягдлын менежмент | 6 | 6 | - |
| 6 | Осол эрсдлийн менежмент | - | - | - |
| 7 | Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ | 4 | 4 | 0 |
| 8 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 5 | 4 | 1 |
| 9 | Олон нийтэд тайлагнах үйл ажиллагаа | 4 | 4 | 0 |
| | Нийт | 30 | 27 | 2 |

# 4. СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

4.1. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Ажлын гүйцэтгэл | Нийт зардал мян.төг | Тоо хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хог хаягдлыг дахиврын цехрүү тээвэрлэлтээс тоосжилт үүсэх зам, талбайг услах, замын түйрэнг хусах | Хог тээвэрлэлт | 2023 оны 11 сард Дахиварын цех болон Хогийн цэгрүү орох хэсгийн замд хэт огцом өндөр өөд гарахад хүч алдаж тээврийн хэрэгсэл ухарч алдах, хий эргэх эрсдэлтэй байсан замыг засаж сайжрууллаа. Мөн замын түйрэнг хусч, шаардлагатай тохиолдлуудад энержи ресурс ХХК-аас замын усалгааг хийж ажилладаг. | Үйл ажиллагааны зардлаас | Тогтмол |
| 2 | Хог тээвэрлэх техник хэрэгслүүдээс хорт хий стандартаас хэтэрч ялгарахаас сэргийлж, үзлэг засварыг тогтмол хийх | Дахиврын цех орчимд | Паблик сервис ХХК-ийн хог тээвэрлэлтийн 3 машин, ажилчдын үйлчилгээний нэг машиныг авто оношилгоонд оруулсан бөгөөд яндангаас гарах утааны хэмжээ Монгол улсын стандартаас хэтрээгүй байна. | Үйл ажиллагааны зардлаас | 3 машин |
| 3 | Хаягдал бочка болон тосны филтерийн тосыг халууны аргаар арилгах процессоос үүдэлтэй агаарт гарах бохирдлыг бууруулах үүднээс турбо бурнерийг зааврын дагуу ажиллуулах; | Захиргааны хэсэг | Турбо бурнер шатаах зууханд 2024 онд нийт 2585 ш хаягдал филтер ангилан ялгаж шатаасан ба одоогийн байдлаар 1446 ш хаягдал филтер шатааж гагнаж замын шон хийсэн байна.<br>Мөн турбо бурнер зуухыг аюулгүй ажиллуулах зааврыг боловсруулж, үйл ажиллагаандаа ашиглаж байна. | Үйл ажиллагааны зардлаас | 1ш |
| | НИЙТ ЗАРДАЛ, мян төг | | | - | |

### 4.1.1. Хог хаягдлын тээвэрлэлтийн замыг арчлах

2023 оны 11 сард Дахиварын цех болон Хогийн цэгрүү орох хэсгийн замд хэт огцом өндөр өөд гарахад хүч алдаж тээврийн хэрэгсэл ухарч алдах, хий эргэх эрсдэлтэй байсан замыг засаж сайжруулла. Мөн замын түйрэнг хусч, шаардлагатай тохиолдлуудад энержи ресурс ХХК-аас замын усалгааг хийж ажилладаг.



*Зураг 4.1.1.1. Хог тээвэрлэлийн зам*

### 4.1.2. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

Паблик сервис ХХК-ийн хог тээвэрлэлтийн 3 машин, ажилчдын үйлчилгээний нэг машиныг авто оношилгоонд оруулсан бөгөөд яндангаас гарах утааны хэмжээ Монгол улсын стандартаас хэтрээгүй байна. Мөн ашиглалтын үеийн эвдрэл гэмтлээс сэргийлж засвар, үзлэгийн тогтмол хийж ажиллав.


ТЕХНИК
АШИГЛАЛТЫН
ПАСПОРТ №

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ №

ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН НЭР

МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА

ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № - 1240122341457

| | |
|---|---|
| ТТД / Регистр: | 69001229843 / 3614263 |
| Татвар төлөгчийн нэр: | Пабликсервис |
| Татварын төрөл: | 01030717 - Автын агаарын бохирдлын төлбөр |
| Харъяалах татварын алба: | Өмнөговь / Аймгийн төвлөрсөн |
| Төлсөн дүн: | 5,000.00 ₮ |
| Гүйлгээний огноо: | 2024-02-15 16:02:10.0 |
| Гүйлгээний утга: | 1240122341457; 69001229843; 3614263; 5806ӨМЕ; Пабликсервис; 88082425;Төрийн банк "ӨМНӨГОВЬ ЦОГТЦЭЦИЙ-2" ТООЦООНЫ ТӨВ ҮҮРИЙНТУЯА;88082425 |
| Татварын данс: | ТЕГ.Автын АБТ - 100900000414 |
| Төлөлтийн хэлбэр: | Төрийн банк |

*Зураг 4.1.2 Техникийн үзлэгийн хуудас*

### 4.1.3. Хаягдал филтер цэвэрлэх төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангах

Турбо бурнер шатаах зууханд 2024 онд нийт 2585 ш хаягдал филтер ангилан ялгаж шатаасан ба одоогийн байдлаар 1446 ш хаягдал филтер шатааж гагнаж замын шон хийсэн байна.



*Зураг 4.1.3 Турбо бурнер ашиглан тосыг цэвэрлэж байгаа байдал*

**4.2. Газар доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр**

| № | Байгаль орчны хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Ажлын гүйцэтгэл | Нийт зардал мян.төг | Тоо хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үйл ажиллагаа үйлчилгээ явуулдаг Цэций хорооллын оршин суугчдад усыг хэмжнэх талаар мэдээлэл өгөх; | Цэций хорооллын цайны газар | Цэций хорооллын байр бүрт мэдээлэл өгөх зорилгоор групп чатуудыг нээж ус, хог, хаягдал, цэвэрлэгээ, дулаан алдалт зэрэгтэй холбоотой мэдээллүүдийг тогтмол өгч ажилласан. | 300’0 | 2 удаа |
| 2 | Ус түгээлтийн худгууд дээр усыг үр ашиггүй асгарахаас сэргийлэх, дотоод хяналт хийх. | Уурхайчин хорооллын 4 худаг | Уурхайчин хорооллын түгээх 1,2,3,4-р худгуудын дотоод хяналтыг сар бүр хийж ажиллаж байна. Шалгалтыг хийхдээ “Үндны ус түгээх байдалд шалгалт хийх хуудас” ашиглан асуулгын дагуу оноо тавих байдлаар үнэлдэг. | Үйл ажиллагааны зардлаас | |
| | НИЙТ ЗАРДАЛ, мян төг | | | 300.0 | |

### 4.2.1. Ус хэмнэх талаарх мэдээлэл

Цэций хорооллын байр бүрээр мэдээлэл өгөх сошил группүүдийг үүсгэж ус хэмнэлт, засвар үйлчилгээ, хуванцар савны ангилан ялгалт зэрэг мэдээллийг тогтмол өгч ажиллаж байна.




*Зураг 4.2.1.1. Усны хэмнэлтийн таолаар мэдээлэл өгсөн байдал*

### 4.2.2. Ус түлгээх худгийн хяналт

Уурхайчин хорооллын түгээх 1,2,3,4-р худгуудын дотоод хяналтыг сар бүр хийж ажиллаж байна. Шалгалтыг хийхдээ "Ундны ус түгээх байдалд шалгалт хийх хуудас" ашиглан асуулгын дагуу оноо тавих байдлаар үнэлдэг.





№6 УНДНЫ УС ТҮГЭЭХ БАЙДАЛД ШАЛГАЛТ ХИЙХ ХУУДАС

Шалгуулагчын нэр, албан тушаал
Үйл ажиллагааны чиглэл
Хяналт шалгалт хийсэн огноо... 2024.4.12

Шаардлага хангасан асуултын тоо
Эрсдэл үүсэх магадлалын хувь:
Шаардлага хангаагүй нийт оноо:
Эрсдэл үүсэх магадлал

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУЛТУУД, ҮНЭЛГЭЭ

| № | Хууль тогтоомж, дүрэм журам, стандартын нэр, зүйл, заалт | Асуултууд | Батлагдсан оноо: Шаардлага хангасан | Батлагдсан оноо: Шаардлага хангаагүй | Авсан оноо |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ажлын байрны тодорхойлтод заасан ажил үүргийн хувьд | Бүртгэл тооцоо хийсэн байдал | 0 | 3 | 0 |
| 2 | | Нөөцийн саванд ариутгал халдваргүйтэл хийлгэдэг эсэх | 0 | 3 | 0 |
| | | Ажлын байрны эмх цэгц | 0 | 3 | 0 |
| | | Хуваарийн дагуу эрүүл чанартай ус түгээх | 0 | 3 | 0 |
| | | Ус түгээх шланг цэвэрхэн байх | 0 | 3 | 0 |
| | ХАБЭА-н тухай хуулийн 18.2.5 | Үйлчилгээний ажилчид нь хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслээр бүрэн хангагдсан | 0 | 5 | 0 |
| | | Үйлчилгээний ажилчид нь эрүүл мэндийн үзлэгт хамрагддаг | 0 | 5 | 0 |
| | | Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг хэрэглэж хэвшсэн. | 0 | 10 | 0 |
| | Ус түгээх сүлжээний хяналт | Ундны ус түгээх байрын барилга байгууламж нь зураг төслийн дагуу баригдсан | 0 | 3 | 0 |
| | | Ундны ус түгээх байр шаардлага хангасан хайс хашаа барьсан | 0 | 3 | 3 |
| | | Ундны ус түгээх байрны гадна орчныг тохижуулж зүлэгжүүлсэн | 0 | 3 | 3 |
| | | Ундны ус түгээх байранд ус зөөж авчрах тээврийн хэрэгслийн зогсох талбайг тэгшлэн бетонлож усыг бүрэн юүлэх боломжоор хангасан | 0 | 3 | 5 |
| | | Ус нөөцлөх савны ус хүлээн авах зориулалтын хоолойг таглаж, лацдан, усыг бохирдлоос хамгаалах нөхцлийг бүрдүүлсэн | 0 | 3 | 0 |
| | | Ундны ус түгээх хоолойг газраас дээш 80 см-ээс доошгүй өндөрт олгох байдлаар байршуулсан | 0 | 3 | 0 |

*Зураг 4.2.2.1. Ус түгээх худаг болон шалгах хуудас*

4.3. Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Ажлын гүйцэтгэл | Нийт зардал мян.төг | Тоо хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Дахиврын цехийн хатуу хучилттай талбайгаас бусад хэсэгт хог хаягдлыг тархаахгүй байх; | Дотоод хяналтын ажилтан | Хог хаягдал хүлээн авах талбайн эргэлтийг хуваарийн дагуу зохицуулалт хийснээр талбайн ачааллаас хэтэрсэн хэмжээний хаягдал буулгахгүй байх хог ачилтын хуваарийг мөрдөж байна. | Үйл ажиллагааны зардлаас | |
| 2 | Хог хаягдал тээвэрлэх явцад тэвшнээс хог унах бутрахгүй байх нөхцлийг бүрдүүлж хийсч тархаж болзошгүй хаягдлыг битүү машинаар тээвэрлэх; | Тээвэрлэлт | Уурхайн бүсийн нийт 23 цэгээс хог хаягдлыг тогтсон хууврийн дагуу зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэдэг. . Зам талбайд тээвэрлэлтийн явцад хог тархаахгүй байх үүднээс хөнгөн хийсэх магадлалтай хаягдлыг пресслэгчтэй тээврийн хэрэгслээр, том оврын шахалт авдаггүй хаягдлыг тэвштэй машинаар зөөвөрлөн ажилласан. | 500.0 | Замыг сайжруулсан байх |
| 3 | Хаягдал тос соруулах үйл явцын үед хөрс бохирдохоос сэргийлж тогтмол хяналт тавьж, бүртгэл хөтлөх | Уурхайн засварын төвүүд | Уурхайн бүсээс нийт 3 цэгээс хаягдал тос соруулдаг ба хаягдал тос соруулах үйл явцын үед хөрс бохирдохоос сэргийлсэн тос соруулах бетонон талбайтай. Мөн тос соруулж ачуулсан актыг тухай бүр хөтөлж бүртгэл хяналтын мэдээллийг гаргааж ажиллав. Тос соруулах үед хөрсөн дээр асгаралт үүссэн тохиолдол 2024 онд гараагүй бөгөөд хатуу хучилттай талбайд үүссэн асгаралтыг шингээгч материал болон үртсэнд шингээж авдаг. | - | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | Нефтийн бүтээгдэхүүний үлдэгдэл агуулсан хогийг хатуу хучилттай талбайд авч, үлдэгдэл тосыг шавхах; | Дахивры н талбай | Тус ажил нь Энержи ресурс ХХК-ийн шийдвэрийн дагуу хийгдээгүй, уурхайн хамгаалалттай хашаан дотор дахин хашаа хамгаалалт байх шаардлагагүй гэж шийдвэрлэсэн. | Үйл ажиллага аны зардлаас | |
| 5 | Тосоор бохирдсон хөрс цуглуулах талбайд саармагжуулалтыг хийх, | Дахивры н талбай | Эх үүсвэр дээрээс тээвэрлэн ирсэн тосоор бохирдсон шороог түр хадгалах цэг дээр ангилан ялгаж саармагжуулан аюулгүй болгон ажиллаж байна. Тостой хаягдал буулгах талбайн нийт хэмжээ 10x12x0,15м харьцаатай 120м2 цементэн бетон талбайн талбайтай ба тостой шороо хадгалах талбайн нийт хэмжээ нь 8 м2 цементэн бетон талбай хашлага хаалт хийсэн. | Үйл ажиллага аны зардлаас | |
| | НИЙТ ЗАРДАЛ, мян төг | | | 500.00 | |

**4.3.1 Хог хаягдал хүлээн авах талбайн менежмент**

Хог хаягдлын талбайгаас илүү хэмжээний хаягдал авахгүй байх зохицуулалтыг хийхдээ ачилтын хуваарийг талбайд байх хогны эргэлтийн хэмжээнд тохируулан хуваарилсан бөгөөд ангилан ялгалттай ирдэг шууд хуваарилах боломжтой хаягдал болон ангилан ялгалт хийгдэх хаягдлыг зөрүүлэн хүлээн авах хуваарийг мөрдөн ажиллаж байна. Хог ачилтын хуваарийг мөрдүүлэх үүднээс засварын төвүүдийн хариуцсан ажилтнуудтай уулзалт хийх, ангилан ялгалтыг сайжруулах дотоод хяналтыг тогтмол хийж ажилласан.




АХУЙН БОЛОН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ТАТАН ЗАЙЛУУЛАХ ХУВААРЬ
2024 он

*Хог ачилтын хуваарь*

### 4.3.2. Хог хаягдлын тээвэрлэлт

Уурхайн бүсийн нийт 23 цэгээс хог хаягдлыг тогтсон хуврийн дагуу зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэдэг. Тээвэрлэлтийн үйл ажиллагааг тусгай сургалтанд сууж гэрчилгээ авсан жолооч, ачигч нар удирдан явуулдаг. Тээврийн машиныг техникийн хяналтын улсын үзлэгт хамрагдсан, замын хөдөлгөөнд оролцох зөвшөөрөл авсан 6 сар тутамдаа мэргэжилийн тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэсэн тээврийн хэрэгсэлээр тээвэрлэн явуулж байна. Зам талбайд тээвэрлэлтийн явцад хог тархаахгүй байх үүднээс хөнгөн хийсэх магадлалтай хаягдлыг пресслэгчтэй тээврийн хэрэгслээр, том оврын шахалт авдаггүй хаягдлыг тэвштэй машинаар зөөвөрлөн ажилласан.







*Зураг 4.3.2.1. Хог тээвэрлэлтийн техникүүд*

### 4.3.3. Хаягдал тос соруулах

Ил задгай хаягдсан тос тосолгооны материал нь хөрс болон гүний усанд бохирдол үзүүлэх сөрөг нөлөөтэй тул хаягдал тосыг зөв зохистой цуглуулж, дахин боловсруулах үйлдвэрт хүргэх нь байгаль хамгаалах чухал арга юм.

Уурхайн бүсээс нийт 3 цэгээс хаягдал тос соруулдаг ба хаягдал тос соруулах үйл явцын үед хөрс бохирдохоос сэргийлсэн тос соруулах бетонон талбайтай. Мөн тос соруулж ачуулсан актыг тухай бүр хөтөлж бүртгэл хяналтын мэдээллийг гаргааж ажиллав. Тос соруулах үед хөрсөн дээр асгаралт үүссэн тохиолдол 2024 онд гараагүй бөгөөд хатуу хучилттай талбайд үүссэн асгаралтыг шингээгч материал болон үртсэнд шингээж авдаг.






ПАБЛИК сервис

**Хаягдал тос татан авсан бүртгэл**

2024 он

| Ажил хийгдсэн огноо | Ажил хийгдсэн байршил | Хийж гүйцэтгэсэн компани | Машин механизм | Хэмжих нэгж | Тоо хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| 2024.02.24 | Уурхайн засварын төв | Хай Би Ойл ХХК | 53-97 УБЯ | тн | 56 |
| 2024.03.07 | Уурхайн засварын төв | Хай Би Ойл ХХК | 85-09 УНГ | тн | 56 |
| 2024.03.29 | Тээврийн засварын хэсэг | Хай Би Ойл ХХК | 79-19 УНГ | тн | 26 |
| 2024.04.10 | Уурхайн засварын төв | Хай Би Ойл ХХК | 84-08 УНЗ | тн | 24 |
| 2024.04.18 | Тээврийн засварын хэсэг | Хай Би Ойл ХХК | 84-08 УНЗ | тн | 24 |
| 2024.04.20 | Уурхайн засварын төв | Хай Би Ойл ХХК | 85-09 УНГ | тн | 56 |
| 2024.04.26 | Уурхайн засварын төв | Хай Би Ойл ХХК | 84-08 УНЗ | тн | 24 |
| 2024.05.09 | Уурхайн засварын төв | Хай Би Ойл ХХК | 84-08 УНЗ | тн | 24 |
| 2024.05.19 | Уурхайн засварын төв | Об Ойл ХХК | 00-46 УЕХ | тн | 33 |
| 2024.05.23 | Уурхайн засварын төв | Хай Би Ойл ХХК | 85-09 УНГ | тн | 56 |
| 2024.06.05 | Уурхайн засварын төв | Об Ойл ХХК | 00-46 УЕХ | тн | 33 |
| 2024.06.16 | Баяжуулах засварын төв | Хай Би Ойл ХХК | 85-09 УНГ | тн | 50 |
| 2024.06.26 | Уурхайн засварын төв | Об Ойл ХХК | 00-46 УЕХ | тн | 33 |
| 2024.07.05 | Тээврийн засварын хэсэг | Об Ойл ХХК | 00-46 УЕХ | тн | 22 |
| 2024.07.24 | Уурхайн засварын төв | Хай Би Ойл ХХК | 85-09 УНГ | тн | 50 |
| 2024.08.13 | Уурхайн засварын төв | Об Ойл ХХК | 00-46 УЕХ | тн | 33 |
| 2024.08.26 | Уурхайн засварын төв | Хай Би Ойл ХХК | 84-08 УНЗ | тн | 25 |
| 2024.08.26 | Уурхайн засварын төв | Хай Би Ойл ХХК | 84-06 УКА | тн | 25 |
| 2024.09.03 | Уурхайн засварын төв | Хай Би Ойл ХХК | 84-08 УНЗ | тн | 25 |
| 2024.09.10 | Уурхайн засварын төв | Хай Би Ойл ХХК | 84-08 УНЗ | тн | 25 |
| 2024.09.23 | Уурхайн засварын төв | Хай Би Ойл ХХК | 84-08 УНЗ | тн | 25 |
| 2024.10.15 | Уурхайн засварын төв | Хай Би Ойл ХХК | 84-08 УНЗ | тн | 25 |
| 2024.10.22 | Уурхайн засварын төв | Мон Пити Ойл ХХК | 00-46 УЕХ | тн | 32 |
| | | | | тн | |
| Нийт | | | | | **782** |

### 4.3.4. Тостой торх цэвэрлэх үйл ажиллагаа

Уурхайн үйл ажиллагаанаас гардаг хаягдал пошкийг цуглуулан тээвэрлэж хуулийн шаардлагын дагуу тусгайлан бэлтгэсэн бетонон талбай дээр хадгалдаг ба 2024 онд нийт 1,500 ш хаягдал пошки цуглуулан хадгалсанаас 550 ш аюулгүй болгон сумын иргэдэд хог хийх зориулалтаар ашиглахаар өгсөн байна. Мөн Цогтцэций сумын 100 жилийн ойд зориулан 100 ш пошки хандив болгон өгсөн байна. 2024 оны 10-р сарын байдлаар 850 ш хадгалж байна.






*Зураг 4.3.4.1. Тостой торхны тосыг арилгах үйл явц*

### 4.3.5. Бохирдсон хөрс саармагжуулах талбай

Эх үүсвэр дээрээс тээвэрлэн ирсэн тосоор бохирдсон шороог түр хадгалах цэг дээр ангилан ялгаж саармагжуулан аюулгүй болгон ажиллаж байна. Тостой хаягдал буулгах талбайн нийт хэмжээ 10х12х0,15м харьцаатай 120м2 цементэн бетон талбайн талбайтай ба тостой шороо хадгалах талбайн нийт хэмжээ нь 8 м2 цементэн бетон талбай хашлага хаалт хийсэн байна. Сайтаас гарсан тосоор бохидсон хөрсийг хатуу хучилттай талбайд авах үйл явцыг тасалдуулалгүй ажиллуулсанаар бохирдсон хөрснөөс эрүүл хөрс бохирдох, хур тунадсаар дамжин хөрс ус дам бохирдохоос сэргийлэн ажиллаж байна.





*Зураг 4.3.5.1. Бохирдсон хөрсийг саармагжуулах талбай*

4.4. Ургамал, амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Ажлын гүйцэтгэл | Нийт зардал мян.төг | Тоо хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Дахиврын цех орчимд ургамлан бүрхэвч талхлагдахаас сэргийлж хөрсний элэгдлээс хамгаалах зорилгоор салаа зам үүсгэхгүй байх; | Дотоод хяналтын ажилтан | Уурхайн технологийн замаас дахиврын цехрүү явах замын түйрэнг хусч цэвэрлэсэн ба нэг замаар зорчих тэмдэг тэмдэглээ хийж, бусад машиныг тус замаар зорчуулахгүй байх, олон салаа зам үүсгэхээс сэргийлж хаалт хашилт хийсэн. | 500'0 | |
| 2 | Дахиврын цехээс орчинд хог тархахаас сэргийлж хаягдлын хашаа хамгаалалтыг сайжруулах; | Уурхай орчмын зам | Тус ажил захиалагч талын санаачлагаар хийгдэхээргүй болсон. | - | |
| 3 | Хог тээвэрлэх явцад зам хөндлөн гарч байгаа жижиг хөхтөн болон бусад амьтыг зам хөндлөн гарах боломжоор хангах; Жолооч нарт түүлбокс орох; | Дахиврын талбай | Хог хаягдал тээвэрлэх машины жолооч нарт 2 удаагийн сэдэвчилсэн яриаг хийж хог тээвэрлэх явцах явцад жижиг хөхтөн амьтан болон бусад амьтан зам хөндлөх гарахад анхаарах зүйлс болон амьтан машинд дахйагдах эрсдэл гарсан тохиолдолд аюулыг мэдээллэх хуудас ашиглах заавар өгч ажиллав. | Үйл ажиллагааны зардлаас | |
| 4 | БОАЖГ-аас явуулдаг хулгайн антай тэмцэх сургалт мэдээллийг байгууллага дотроо сэдэвчилсэн яриа байдлаар таниулах; | Компанийн нийт ажилтан | БОАЖГ-аас явуулдаг хулгайн антай тэмцэх сургалт мэдээллийг байгууллага дотроо сэдэвчилсэн яриа байдлаар 2 удаагийн давтамжтай зохион байгуулсан бөгөөд нийт 15 хүн хамрагдсан байна. | Үйл ажиллагааны зардлаас | |
| | НИЙТ ЗАРДАЛ, мян төг | | | 500.00 | |

### 4.4.1. Салаа зам хаах

Уурхайн технологийн замаас дахиврын цехрүү явах замын түйрэнг хусч цэвэрлэсэн ба нэг замаар зорчих тэмдэг тэмдэглээ хийж, бусад машиныг тус замаар зорчуулахгүй байх, олон салаа зам үүсгэхээс сэргийлж хаалт хашилт хийсэн.






*Зураг 4.4.1.1. Замын хаалт тэмдэг тэмдэглэгээ*

### 4.4.3. Хулгайн антай холбоотой сэдэвчилсэн яриа

БОАЖГ-аас явуулдаг хулгайн антай тэмцэх сургалт мэдээллийг байгууллага дотроо сэдэвчилсэн яриа байдлаар 2 удаагийн давтамжтай зохион байгуулсан бөгөөд нийт 15 хүн хамрагдсан байна. Хулгайн антай тэмцэх, түүнтэй холбоотой хуулийн заалтууд, амьтдын экологийн үнэ цэнийн талаар мэдээлэл өглөө.





Эрүүгийн хуулийн 24.5 зүйл, Хууль бусаар ан агнах

2024.4.20

Сургалтанд хамрагдсан ажилчид:

| № | Байгууллагын нэр | Овог Нэр | Албан тушаал | Гарын үсэг |
|---|---|---|---|---|
| 1 | "ПАБЛИК СЕРВИС" ХХК | [illegible] | [illegible] | [illegible] |
| 2 | | [illegible] | [illegible] | [illegible] |
| 3 | | [illegible] | менежер | [illegible] |
| 4 | | [illegible] | [illegible] | [illegible] |
| 5 | | [illegible] | [illegible] | [illegible] |
| 6 | | [illegible] | [illegible] | [illegible] |
| 7 | | [illegible] | тогооч | [illegible] |
| 8 | | [illegible] | [illegible] | [illegible] |
| 9 | | [illegible] | жолооч | [illegible] |
| 10 | | [illegible] | [illegible] | [illegible] |
| 11 | | [illegible] | жолооч | [illegible] |
| 12 | | [illegible] | [illegible] | [illegible] |
| 13 | | [illegible] | цех мастер. | [illegible] |
| 14 | | [illegible] | [illegible] | [illegible] |
| 15 | | [illegible] | ус түгээгч | [illegible] |
| 16 | | | | |
| 17 | | | | |
| 18 | | | | |
| 19 | | | | |
| 20 | | | | |
| 21 | | | | |
| 22 | | | | |
| 23 | | | | |
| 24 | | | | |
| 25 | | | | |
| 26 | | | | |
| 27 | | | | |
| 28 | | | | |

*Зураг 4.4.1.1. Мэдээлэл өгч буй байдал*

#### 4.4.4. Байгаль орчны сэдэвчилсэн яриа

Тээврийн хэрэгсэл жолоодох үеийн аюулгүй ажиллагаа болон машин жолоодох үед мал амьтан дайрахаас сэргийлэх, дайрсан тохиолдолд аюулыг хэрхэн мэдээллэх хариу арга хэмжээ авч ажиллах талаарх сургалт сэдэвчилсэн яриаг зохион байгууллаа.



Ref No: AE-UMG24/01 | Сургалтын бүртгэл | Огноо: 06/19/2024

Монгол улсын ХНХС-н А/173 тоот тушаалын хавсралтаар батлагдсан ХАБЭА-н сургалт явуулах болон шалгалт авах журам, хөтөлбөрийг удирдлага болгон зохион байгуулав.

Сургалтанд хамрагдсан:

| № | Байгууллагын нэр | Албан тушаал | Овог, нэр | Гарын үсэг |
|---|---|---|---|---|
| 1 | "ПАБЛИК СЕРВИС" ХХК | [illegible] | [illegible] | [illegible] |
| 2 | | [illegible] | [illegible] | [illegible] |
| 3 | | [illegible] | [illegible] | [illegible] |
| 4 | | [illegible] | [illegible] | [illegible] |
| 5 | | [illegible] | [illegible] | [illegible] |
| 6 | | [illegible] | [illegible] | [illegible] |
| 7 | | [illegible] | [illegible] | [illegible] |
| 8 | | [illegible] | [illegible] | [illegible] |
| 9 | | [illegible] | [illegible] | [illegible] |
| 10 | | [illegible] | [illegible] | [illegible] |
| 11 | | [illegible] | [illegible] | [illegible] |
| 12 | | [illegible] | [illegible] | [illegible] |
| 13 | | [illegible] | [illegible] | [illegible] |
| 14 | | [illegible] | [illegible] | [illegible] |
| 15 | | [illegible] | [illegible] | [illegible] |
| 16 | | [illegible] | [illegible] | [illegible] |
| 17 | | [illegible] | [illegible] | [illegible] |
| 18 | | [illegible] | [illegible] | [illegible] |
| 19 | | [illegible] | [illegible] | [illegible] |
| 20 | | [illegible] | [illegible] | [illegible] |
| 21 | | [illegible] | [illegible] | [illegible] |
| 22 | | | | |
| 23 | | | | |
| 24 | | | | |
| 25 | | | | |
| 26 | | | | |
| 27 | | | | |
| 28 | | | | |
| 29 | | | | |
| 30 | | | | |

Сургалт зохион байгуулсан:

| № | Байгууллага | Албан тушаал | Овог/Нэр | Гарын үсэг |
|---|---|---|---|---|
| 1 | "Ололт амжилт" сургалтын төв | Сургагч багш | О.Шинэбаяр | [illegible] |



## 5. НӨХӨН СЭРГЭЭЛТ НОГООН БАЙГУУЛАМЖ

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-ийн дагуу эзэмшил газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу зүлэгжүүлж мод тариалах шаардлагыг үүрэгжүүлж өгсөн байдаг.Иймд эзэмшил газрын 10-аас багагүй хувийг тохижилт, агаарын бохирдлыг бууруулах, ургамалжуулах зэрэг зорилгоор моджуулах арга хэмжээг зайлшгүй хийх шаардлагатай юм. "Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах төсөл"-ийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан моджуулах ажлыг БОННҮ-ний тайлан тусгасан зөвлөмжийн дагуу тарих шаардлагатай. “Энержи ресурс” ХХК-ийн уурхай ашиглалтын лицензийн 6116 м.кв  талбайд үйл ажиллагаа явуулах ба энэ хэсэгт ногоон байгууламж хийхгүй.

“Паблик Сервис” ХХК нь Цэций хорооллын урд зам дагуу одой хайлаас говь хээрийн бүсэд тариалахад тохиромжтой мод бут, сөөгийг намар газар хөлдөхөөс 20-иос доошгүй хоногийн өмнө буюу 10 дугаар сарын 5-20-ны хооронд, хавар 4 дүгээр сарын 20-ноос 5 дугаар сарын 15-ны хооронд тарихад тохиромжтой. Тарьсан ургамлыг ургах чадвартай болтол усалж арчилна.




“Паблик Сервис” ХХК нь Цэций хорооллын урд зам дагуу одой хайлаас говь хээрийн бүсэд тариалахад тохиромжтой мод бут, сөөгийг 2023 оны 5-р сарын 6-ны өдөр 200 ш хайлаас модыг тарьж ургуулаад байна.

Суулгац суулгах нүхний хэмжээ:

- Хайлаасны  суулгацыг нүхэнд тарина.
- Нэг настай суулгацыг тарих нүхний голч 20-30 см, гүн нь 30 см байна.
- 2-3 настай суулгацанд 40-50 см голчтой, 50 см гүн нүх тохирно.
- Суулгац суулгах мөр хоорондын зай 3 м, ургамал хоорондын зай  2 м байна.




*Зураг 5.1.1 Эхнийх нь нэг настай, дараачийнх нь 2-3 настай суулгац тарих бүдүүвч*

*Хүснэгт: Ногоон байгууламж хийх төлөвлөгөөний биелэлт*

| **№** | **Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ** | **Хамрах хүрээ** | **Ажлын гүйцэтгэл** | **Нийт зардал мян.төг** | **Тоо хэмжээ** |
|---|---|---|---|---|---|
| 1 | Тэр бум мод хөтөлбөрийг хэрэгжүүлж хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх | Цэций хороолол | Цэций хорооллын зам дагуу 200 ш хайлаас тарьж арчилж хамгаалж байна. Мөн хорооллын байр бүрийн гадна талын ногоон байгууламжид 80 ширхэг модыг нөхөн тарьсан. | 600.000 | 200 ш |
| 2 | | Цэций хороолол | 440мкв талбайг зүлэгжүүлэх ажлыг гүйцэтгэж, усалгааг тогтмол хийсэн. | Үйл ажиллагааны зардлаас | 440мкв |
| **Ногоон зурвас байгуулах төлөвлөгөөний зардал мян.төг** | | | | **600'0** | |

### 5.1.1 Ногоон байгууламжийн арчилгаа, нөхөн тарилт

Цэций хорооллын зам дагуу 200 ширхэг хайлаас модыг тарьсан. Хорооллын зам дагуух тарьсан модны усалгааг 5-10-р сарын хугацаанд хуваарийн дагуу хийсэн бөгөөд 10-р сарын 2 дахь 7 хоногоос намрын цэнэг усалгаа хийж өвлийн бэлтгэл ажлыг хангаж ажиллав.







Зураг 5.1.2 *Цэций хорооллын урд зам дагуу мод тарьж байгаа байдал*

**5.2.1 Зүлэгжүүлэлт**

Цэций хороолол орчмын нийтийн эзэмшлийн талбайд 440мкв талбайг харицан хашаажуулж, хөрс бэлтгэлийг хийж зүлэгжүүлэх ажлыг зохион байгуулав. Тус зүлгийг хуваарийн дагуу өдөр бүр усалгаа хийсэн бөгөөд ногоон массын бүрхэц 80-90% байв. Тус зүлэгжүүлэлтийн

ажлыг хийснээр орчны тоосжилт бууруулах, оршин суугчдад тав тухтай орчин бүрдүүлэх, агаарыг чийгшүүлэх ач холбогдолтой байна.





Зураг 5.1.2 *Зүлэгжүүлэлтийн ажил хийж байгаа байдал*

## 6. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Ажлын гүйцэтгэл | Нийт зардал мян.төг | Биелэлтийн шалгуур |
|---|---|---|---|---|---|
| 1 | Цогтцэций орчимд нүүдлийн цагаан зээрэнд идэш тэжээл хангах | Уурхай орчимд | Биотехникийн арга хэмжээ зохион байгуулж дахиврын цехийн хойд талбайд нутагладаг зээрэнд өвс тавьж өгөх. | 300’0 | 20 боодол өвс |
| 2 | Зэрлэг амьтдын амьдрах орчныг сайжруулах | Уурхай орчимд | Амьтдын амьдрах орчинг сайжруулах зорилгоор талбай орчмын цагаан зээрийн бэлчээрийн талбайн хог хаягдлыг тогтмол түүж цэвэрлэх, | 200’0 | 2 га талбайг цэвэрлэх |
| | НИЙТ ЗАРДАЛ, мян.төг | | | 500.0 | |

### 6.1.1 Өвс тэжээл тавих

Паблик сервис ХХК нь тус ажлын хүрээнд уурхайн орчимд бэлчээрлэх зээрийн сүргийн бэлчээрийг тосч 2 удаагийн давтамжтайгаар 10 боодол өвсийг тавьсан.

### 6.1.2 Зам талбайд хийсч тарсан хог хаягдлын цэвэрлэгээ зохион байгуулах

Төслийн талбайн зам талбайд хийсэж тарсан хогны цэвэрлэгээг 2024 онд 22 удаа хийж нийт 44 м3 хогийг зайлуулсан байна. Түүнчлэн сумын засаг даргаас ирүүлсэн албан бичгийн дагуу Цогтцэций сумын 100 жилийн ойд зориулсан өргөн хүрээтэй их цэвэрлэгээнд 45 хүний бүрэлдэхүүнтэйгээр 4 өдрийн турш оролцож нийт 124 м3 хогийг цэвэрлэн зайлуулсан байна.





Зураг 10.2.1. *Хээрийн  хог цэвэрлэгээг хийж байгаа байдал*

**7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Ажлын гүйцэтгэл | Нийт зардал мян.төг | Тоо хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| 1 | Нөлөөллийн бүсийн айл өрхөд өвс тэжээлийн дэмжлэг үзүүлэх | Ухаа худаг төсөл | Цогтцэций сумын өвөлжилт хүндэрсэн 2 өрхөд нийт 30 боодол өвс 50 шуудай тэжээлийн дэмжлэг үзүүлэв. | 900’0 | 30 боодол өвс<br>50 уут тэжээл |
| **Нийт зардал** | | | | **900’0** | |




Зураг 10.1. *Өвс тэжээлийг тараж байгаа нь*

## 8. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах төслийн талбай нь Цогтцэций сумаас баруун тийш 4.1 км-т Энержи Ресурс ХХК-ийн газар эзэмших эрх бүхий 600 га талбайд 6116 м.кв газар дээр хэрэгжиж байна. Газар ашиглалтын хувьд Ухаа худаг төслийн талбайд байрших тул нүүлгэн шилжүүлэх шаардлага үүсэхгүй.

Төслийн талбай болон түүний орчмын нутагт нь түүх соёлын дурсгалд тооцож болохуйц газар болон археологийн болон палентологийн олдвор одоогоор тохиолдоогүй.

Цаашид үйл ажиллагааны явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед "Монгол Улсын Үндсэн хууль"-ийн I бүлгийн 7-р зүйлд "Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна" гэж заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөж ажиллах нь зүйтэй.

Соёлын ба үнэт өв зүйлсийг илрүүлж, тэр нь төслийн үйл ажиллагаанд эрсдэхээр байвал орон нутгийн засаг даргаас энэ үйл ажиллагааг даруй зогсоохыг шаардах, бололцоотой бол эдгээр газруудыг аль болох зохистойгоор хамгаалахыг хуульд заасан байдаг. Боловсрол, Соёл, ШУ-ны яамны тусгай зөвшөөрөлгүйгээр зөөж шилжүүлэх боломжгүй соёлын ба үнэт дурсгалын өвийг малтах, зөөх, эвдэхийг хуулиар хориглосон.

## 9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Ажлын гүйцэтгэл | Нийт зардал мян.төг | Биелэлтийн шалгуур |
|---|---|---|---|---|---|
| 9.1 | Ажиллагсдын мэдлэг дутуугаас аюул эрсдэлд өртөх | ПС нийт ажилчид | 2024 оны 6-р сарын 19-ны өдөр “Паблик сервис” ХХК-ны нийт ажилчдийн сургалтыг Ололт амжилт сургалтын төвтэй хамтран ХАБЭА сургалтыг зохион байгуулан ажиллалаа. | Үйл ажиллагааны зардлаас | Жилд 1 удаа |
| 9.2 | Галын аюулын үед хэрэгжүүлэх арга хэмжээ мэдлэг дутуугаас үүсэх эрсдэл | ПС нийт ажилчид | 2024 оны 5-р сарын 2-ны өдөр Цогтцэций сум дахь онцгой байдлын хэлтсийн гал түймэр унтраах, аврах 44 дүгээр ангид “Паблик сервис” ХХК-ийн нийт 18 | Үйл ажиллагааны зардлаас | Жилд 1 удаа |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | ажилтан галын аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх, галын хорыг хэрхэн ашиглах талаарх онол практикынсургалтыг зохион байгууллаа. | | |
| 9.3 | Галын хорны бэлэн байдал хангагдаагүйгээс аюул эрсдэл үүсэх | ПС нийт ажилчид | | | Жилд 1 удаа |
| 9.4 | Аюултай хог хаягдлын аюулгүй байдал алдагдсанаас гарах эрсдэл | Ангилан ялгагч болон жолооч нар | | | Жилд 1 удаа |
| 9.5 | Тос тосолгооны материал хадгалах талбайд гал болон үер усны аюулд өртөх | Дахивар цех | | | Жилд 1 удаа |
| НИЙТ ЗАРДАЛ, мян.төг | | | | - | |

**9.1 Аюулгүй ажиллагааны сургалт**

2024 оны 6-р сарын 19-ны өдөр “Паблик сервис” ХХК-ны нийт ажилчдийн сургалтыг Ололт амжилт сургалтын төвтэй хамтран ХАБЭА сургалтыг зохион байгуулан ажиллалаа.






**9.2 Галын аюулгүй ажиллагааны сургалт**

2024 оны 5-р сарын 2-ны өдөр Цогтцэций сум дахь онцгой байдлын хэлтсийн гал түймэр унтраах, аврах 44 дүгээр ангид “Паблик сервис” ХХК-ийн нийт 18 ажилтан галын аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх, галын хорыг хэрхэн ашиглах талаарх онол практикынсургалтыг зохион байгууллаа.





### 9.3 Аюултай хог хаягдлын хадгалалтыг сайжруулах

Хог хаягдлын ангилан ялгалтын цэгийн аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс сэргийлэх зорилгоор Энержи Ресурс ХХК-ийн БОХАБЭА-н багтай хамтарсан үзлэгийг хийж сайжруулалтуудыг хийсэн. Хадгалж буй хаягдлуудыг ангилан ялгах, ажлын байруудад анхны тусламжийн хайрцаг байршуулах зэрэг ажлуудыг хийсэн.





## 10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Ажлын гүйцэтгэл | Нийт зардал мян.төг | Биелэлтийн шалгуур |
|---|---|---|---|---|---|
| 1 | Уурхай орчмын зам талбайд цэвэрлэгээ зохион байгуулах | Хог хаягдал түр хадгалах цэгүүд | Төслийн талбайн зам талбайд хийсэж тарсан хогны цэвэрлэгээг 2024 онд 22 удаа хийж нийт 44 м3 хогийг зайлуулсан байна. Түүнчлэн сумын засаг даргаас ирүүлсэн албан бичгийн дагуу Цогтцэций сумын 100 жилийн ойд зориулсан өргөн хүрээтэй их цэвэрлэгээнд 45 хүний бүрэлдэхүүнтэйгээр 4 өдрийн | Үйл ажиллагааны зардал | 124 метр куб |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | турш оролцож нийт 124 м3 хогийг цэвэрлэн зайлуулсан байна. | | |
| 2 | Хуванцарын хог хаягдлыг ангилан ялгаж, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх | Төслийн талбай | 2024 онд нийт 267 м3 хаягдал хуванцар савыг “Эс И Эс Эл Смарт Солюшн” ХХК-д нийлүүлээд байна. | | |
| 3 | Хаягдал тосыг шаардлага хангасан нөхцөлд цуглуулж, эрх бүхий байгууллагад нийлүүлэх | Хог хаягдал түр хадгалах цэгүүд | Төслийн хэмжээнд энэ онд 782тн хаягдал тос үүссэн ба засварын төвд суурилуулсан 50 тн багтаамжтай зориулалтын ёмкостонд цуглуулж, хаягдал тос дахин боловсруулдаг “Об ойл” ХХК ,“Хай би ойл ” ХХК, “Монпити ойл” ХХК -иудтай гэрээ байгуулж хаягдал тосоо нийлүүлэн хамтарч ажиллаж байна. | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | Аюултай хог хаягдлын зохицуулалтыг сайжруулж 2-с доошгүй хаягдлын зохицуулалыг сайжруулах; | Хог хаягдал түр хадгалах цэгүүд | Уурхайн үйл ажиллагаанаас гарсан хаягдал хуруу зайг тусгайлан бэлдсэн агуулхад нийт 1602 ш зохих шаардлагын дагуу хадгалж байна.<br>Хаягдал галын хорыг эх үүсвэрүүдээс татан зориулалтын талбайд татан төвлөрүүлж хуулийн хугацаанд түр хадгалдаг ба 2024 онд тусгай зөвшөөрөл бүхий “Эрчим гал” ХХК-тай гэрээ хийж хамтран ажиллаж байна. Энэ онд нийт 2026 ширхэг хаягдал галын хорыг тус компанид нийлүүлээд байна. Түүнчлэн одоогийн байдлаар буюу 10-р сарын 20-ны өдрийн байдлаар 400 ширхэг галын хорыг цуглуулан түр хадгалж байна. | 500’0 | |
| 5 | Хог хаягдлаар дахивар бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулах | Алба хэсгүүд Паблик сервис ХХК | Хог хаягдлыг дахин боловсруулж ашиглах ажлын хүрээнд хаягдал тосны филтерийг тосноос нь салгаж гагнан уурхайн аюулгүйн шонг үйлдвэрлэж байна. | | |
| 6 | Аюултай хог хаягдлыг нийлүүлэгч тал болон эрх бүхий байгууллагад буцаан хүргүүлэх, нийлүүлэх | Засварын төвүүд | Уурхайн үйл ажиллагаанаас гардаг хаягдал өдрийн гэрэлийг цуглуулан тээвэрлэж хуулийн шаардлагын дагуу хадгалдаг ба тусгай зөвшөөрөлтэй “Нью метод” ХХК-тай 2024 онд гэрээ хийж хамтран ажиллаж байна. 2024 онд нийт 500 ширхэг хаягдал өдрийн гэрэлийг “Нью метод” ХХК-д нийлүүлээд байна. 2024 оны 10-р сарын байдлаар 161 ш хадгалж байна. | | |
| | **НИЙТ ЗАРДАЛ, мян.төг** | | | **500.0** | |

### 9.1 Зам талбайд хийсч тарсан хог хаягдлын цэвэрлэгээ зохион байгуулах

Төслийн талбайн зам талбайд хийсэж тарсан  хогны цэвэрлэгээг 2024 онд  22 удаа хийж нийт  44 м3 хогийг зайлуулсан байна. Түүнчлэн сумын засаг даргаас ирүүлсэн албан бичгийн дагуу Цогтцэций сумын 100 жилийн ойд зориулсан өргөн хүрээтэй их цэвэрлэгээнд 45 хүний бүрэлдэхүүнтэйгээр 4 өдрийн турш оролцож нийт  124 м3 хогийг цэвэрлэн зайлуулсан байна.



Зураг 10.2.1. *зам дагуу болон ,сумын хээрийн  хог цэвэрлэгээг хийж байгаа байдал*

### 9.2. Хуванцар ангилан ялгалт

Уурхайн үйл ажиллагаанаас гардаг  хуванцар хог хаягдлыг цуглуулан тээвэрлэж тусгайлан бэлдсэн талбайд ангилан ялгаж Цогтцэций суманд үйл ажиллагаа явуулдаг “Дүүрэн Цэций” ХХК-д 48 м3 хуванцар нийлүүлж Улаанбаатар хотод  хаягдал хуванцар сав дахин боловсруулдаг “Эс И Эс Эл Смарт Солюшн” ХХК -тай  2024 онд гэрээ хийж хамтран ажиллаж байна. 2024 онд нийт 267 м3 хаягдал хуванцар савыг “Эс И Эс Эл Смарт Солюшн” ХХК-д нийлүүлээд байна. Одоогоор  дахиварын цехд үлдсэн 66,5 м3-ыг дахиварын цех дээрх хуванцар хадгалах хашаанд ангилан ялган  хадгалаад байна.



Зураг 10.1  *Хуванцар савыг цуглуулж ангилан ялгаж тээврэлсэн  байдал*

### 9.3  Хаягдал тосыг цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх

Ил задгай хаягдсан тос тосолгооны материал нь хөрс болон гүний усанд бохирдол үзүүлэх сөрөг нөлөөтэй тул хаягдал тосыг байгальд сөрөг нөлөөлөлгүйгээр цуглуулж, дахин боловсруулах үйлдвэрт хүргэх нь байгаль хамгаалах чухал арга хэмжээ юм.
Төслийн хэмжээнд энэ онд 782тн хаягдал тос үүссэн ба засварын төвд суурилуулсан 50 тн багтаамжтай зориулалтын ёмкостонд цуглуулж, хаягдал тос дахин боловсруулдаг “Об ойл”

ХХК ,“Хай би ойл ” ХХК, “Монпити ойл” ХХК -иудтай гэрээ байгуулж хаягдал тосоо нийлүүлэн хамтарч ажиллаж байна.



АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, УСТГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ

ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар 0000009 Олгосон: 2020.07.01

Хавсралт 1 -д заасан нөхцлийн дагуу аюултай хог хаягдал Авто тээврээс гарч буй ашиглагдсан тосыг тээвэрлэх, цуглуулах хадгалах, дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 9010001063 улсын бүртгэлийн дугаартай 2615134 регистрийн дугаартай “Хай би Ойл” ХК -д 2020 оны 06 дугаар сарын 29 -ны өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 29 -ны өдөр 5 жилийн хугацаагаар олгов.

Үйл ажиллагаа эрхлэх талаарх мэдээлэл:

Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгэлийн дугаар 0000009

Аж ахуйн нэгж/иргэний хаяг: Улаанбаатар аймаг, хот Сонгинохайрхан сум, дүүргийн 20-р баг, хорооны Үйлдвэрлэл нүүрсний газрын урд

Зөвшөөрөл олгосон үйл ажиллагаа явуулах газрын байршил: Улаанбаатар аймаг, хот Сонгинохайрхан сум, дүүргийн 20-р баг, хорооны Үйлдвэрлэл нүүрсний газрын урд

Хавсралт нь энэхүү зөвшөөрлийн салшгүй нэг хэсэг болно.

Зөвшөөрөл олгосон:

БОАЖ-ын сайд (байгууллагын нэр, албан тушаал) (гарын үсэг, тамга) Н.Цэрэнбат (овог нэр)



“ХАЙ БИ ОЙЛ” ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ш.АМАР-ОТГОН

“ПАБЛИК СЕРВИС” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ КАЛАМКАС

ТЕХНИКИЙН ХАЯГДАЛ ТОС БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

2024 оны 1 -р сарын 2 -ны өдөр № АХХ-24/01 Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа 2615134 тоот регистрийн, 90100011063 тоот улсын бүртгэлийн дугаартай “Хай Би Ойл” ХК- г төлөөлж үйлдвэрийн менежер ажилтай Л.Даваагэрэл , нөгөө талаас Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа 3614263 тоот регистр, 1111003063 тоот улсын бүртгэлийн дугаартай “Паблик сервис” ХХК -ийг төлөөлж ХАБЭА-БО -ны мэргэжилтэн ажилтай ерөнхий менежер ажилтай Г.Саруултуяа нар дор дурдсан зүйлийг харилцан тохиролцсоны үндсэн дээр Монгол Улсын Иргэний /380-397/ хууль, Хог хаягдлын тухай хуулийн /Дөрөвдүгээр бүлэг, Хоёр дугаар бүлэг 10 дугаар зүйл, Тавдугаар бүлэг/ холбогдох зүйл заалтыг баримтлан энэхүү Аюултай хог хаягдал буюу техникийн ажилласан тос хүлээн авч тээвэрлэх гэрээг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ,

1.1 Энэхүү гэрээгээр “Хай Би Ойл” ХК болон “Паблик сервис” ХХК-ийн Өмнөговь аймгийн Цогт Цэций сумаас гэрээнд заасан хугацаанд машин механизмын, тоног төхөөрөмжийн, хөдөлгүүрийн, гидрийн болон моторын тосыг солих үед гарах техникийн хаягдал тос буюу аюултай хог хаягдал /шаащил "АХХ" гэх/-г цуглуулах, тээвэрлэх, бэлтгэн нийлүүлэх болон бусад холбогдох харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэхүү гэрээ нь талуудын хооронд хийгдсэн тохиролцоонуудыг агуулж байгаа бөгөөд энэхүү гэрээнд тодорхой байдлаар тусгаж оруулсан заалтуудыг оролцуулахгүйгээр Үйлчилгээтэй холбоотой хэлцэл, мэдэгдэл, аман болон бичгээр хийсэн тохиролцоог энэхүү гэрээ орлож байгаа болно.

1.3 Энэхүү гэрээнд өөрөөр заагаагүй бол түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, хоёр тал гарын үсэг зурааагүй бол тэдгээрийг хүчин төгөлдөр бус гэж үзнэ.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

2.1 Энэхүү гэрээ нь “Хай Би Ойл”ХК болон “Паблик сервис” ХХК-ийн төлөөлөлүүд гарын үсэг зурснаар 2024 оны 1 сарын 2-ны өдрөөс 2024 оны 12 сарын 31-ны өдрийг хүртэл хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

2.2 Гэрээнд оролцогч талууд Монгол Улсын Иргэний хуульд заасныар гэрээний үүргээ бүрэн буюу хэсэгчлэн биелүүлээгүй гэж үзсэн тохиолдолд гэрээг дуусгавар болгохыг санал болгох эрхтэй.

2.3 Гэрээний хугацаа дуусгавар болоход талууд гэрээг үргэлжлүүлэх эсэх талаар харилцан мэдэгдэж зөвшилцөнө.



2015 оны 02 сарын 02-ны өдрийн А/21 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ

| № | Аюултай хог хаягдлын нэр | Аюулын ангилал | | Савлагаа | | Хэмжээ | Нэгж | Аюултай хог хаягдлын код |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хаягдал тос | А | | | | 56 | тн | [illegible] |
| 2 | | | | | | | | |
| 3 | | | | | | | | |

Зураг 10.8.1. *“Хай би Ойл”ХХК-н тусгай зөвшөөрлийн гэрчилгээ“Монпити Ойл ”ХХК-н “Об Ойл” ХХК гэрээтэй, дагалдах хуудас*





Зураг 10.8.2. *Хаягдал тос тээврийн машин*

**10.4 Аюултай хог хаягдлын зохицуулалт**

Хаягдал галын хорыг эх үүсвэрүүдээс татан зориулалтын талбайд татан төвлөрүүлж хуулийн хугацаанд түр хадгалдаг ба 2024 онд тусгай зөвшөөрөл бүхий “Эрчим гал” ХХК-тай гэрээ хийж хамтран ажиллаж байна. Энэ онд нийт 2026 ширхэг хаягдал галын хорыг тус компанид нийлүүлээд байна. Түүнчлэн одоогийн байдлаар буюу 10-р сарын 20-ны өдрийн байдлаар 400 ширхэг галын хорыг цуглуулан түр хадгалж байна.





"ЭРЧИМ ГАЛ"ХХК

ГАЛЫН ХОР УСТГАХ ТЕХНИКИЙН КОМИССЫН АКТ

2024 он 2 сар 28 өдөр №24/01 Улаанбаатар хот

"Эрчим ресурс ХХК"-ийн дахин цэнэглэх боломжгүй хэрэгцээний шаардлага хангахгүй, актлах болсон галын хор.

| Д/Д | МАРК ТӨРӨЛ | ТОО ХЭМЖЭЭ |
|---|---|---|
| 1 | ABC-35кг. Нунтаг галын хор | 55 |
| 2 | ABC-9кг — " — | 280 |
| 3 | ABC-6кг — " — | 420 |
| 4 | $CO_2$-24кг Нүүрсхүчлийн хийн — " — | 45 |
| 5 | $CO_2$-5кг Нүүрсхүчлийн хийн — " — | 85 |
| 6 | ABC 4;5кг Нунтаг гал унтраагуур | 435 /1320 |

Актлах болсон шалтгаан:

- Эх бие залгаастай/ ил гагнаастай, өндөр даралт даахгүй/ 88
- Клап барихгүй болсон /хий алдаж, битүүмжлэл алдсан/ 760
- Баллоны ашиглалтын хугацаа дууссан/ өндөр даралт даах чадваргүй болсон/ 320
- Их бие механик гэмтэлтэй/ цохигдож хонхойсон, эвдэрсэн/ 102
- Ашиглалтын хугацаа дууссан /10-аас дээш жил болсон/
- Сэлбэх хэрэгсэл байхгүй /....... Оноос өмнө үйлдвэрлэсэн/ 46
- Бусад........4........ зэрэг галын хорны савыг дахин цэнэглэж ашиглах боломжгүй болсныг дүгнэж байна.

"Эрчим гал" ХХК төлөөлөгч:

Инженер........ /Л.Эрдэнэ/

Галын хор цэнэглэгч........ /Эрдэнэжаргал/

Имэйл: info@erchimgal.mn Утас: 80066710, 80066701



Уурхайн үйл ажиллагаанаас гарсан хаягдал хуруу зайг тусгайлан бэлдсэн агуулхад нийт 1602 ш зохих шаардлагын дагуу хадгалж байна.

**Хог хаягдлыг дахин ашиглах**

Дахиварын цех дээр хаягдал акумлятор хадгалах байр шинээр барьсан ба одоогийн байдлаар хаягдал акумляторыг зохих шаардлагын дагуу хадгалж байна.





*Зураг 4.1.1 Хаягдал филтерээр аюулгүйн шон хийх*

**Аюултай хог хаягдал болох хаягдал өдрийн гэрлыг эрх бүхий компанид хүргүүлэх**

Уурхайн үйл ажиллагаанаас гардаг хаягдал өдрийн гэрэлийг цуглуулан тээвэрлэж хуулийн шаардлагын дагуу хадгалдаг ба тусгай зөвшөөрөлтэй "Нью метод" ХХК-тай 2024 онд гэрээ хийж хамтран ажиллаж байна. 2024 онд нийт 500 ширхэг хаягдал өдрийн гэрэлийг "Нью метод" ХХК-д нийлүүлээд байна. 2024 оны 10-р сарын байдлаар 161 ш хадгалж байна.





Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2018 оны 02 сарын 02-ны өдрийн А/21 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ
№
Дагалдах бичгийн дугаар:
/ шаардлагатай тохиолдолд нэмэлт хуудас хэрэглэнэ. /

1.Үүсгэгчийн талаарх мэдээлэл:
Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар: Ү- 0000030
Аюултай хог хаягдал үүсгэгч байгууллагын нэр: ....................

2. Аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгсөн:
Овог нэр ... Албан тушаалтан ... Гарын үсэг ... Огноо: 2024 он ... сар ... өдөр

3. Тээвэрлэгчийн талаарх мэдээлэл:
1/ Тээврийн хэрэгслийн улсын дугаар: ............ Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар:............

4. Аюултай хог хаягдлын талаарх мэдээлэл:

| | Аюултай хог хаягдлын нэр | Аюулын ангилал дын хэрэгтэл | Савлагаа ны бүлэг | Савны дугаар | Савны Төрөл | Хэмжээ | Нэгж /кг Эсвэл/ ш | Аюултай хог хаягдлын код |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Өдрийн гэрэл | I | I | | | | 500 | 16-07. |
| 2 | Компьютер | I | I | | | | 25 | 16 07. |
| 3 | | | | | | | | |
| 4 | | | | | | | | |
| | | | | | | | | |

5. Тээвэрлэх үед анхаарах нэмэлт зааварчилгаа, мэдээлэл:

5. Аюултай хог хаягдлыг хүлээн авсан тээвэрлэгч :
1. Овог нэр:.................. Гарын үсэг:.................. 2024он ..... сар...... өдөр

6. Үл зохицол:

8. Аюултай хог хаягдлыг хүлээн авагчийн талаарх мэдээлэл:
Аж ахуйн нэгжийн нэр: НЬЮ МЕТОД ХХК
Нью метод ХХК бүртгэлийн дугаар: Б-001898 Ү-0000030
Аюултай хог хаягдлыг хүлээн авсан:
Овог нэр : Нью метод ХХК ... Албан тушаал ... Гарын үсэг/ тамга / ... Огноо 2024 он ... сар ... өдөр

НЬЮ МЕТОД ХХК

*Зураг. Хаягдал өдрийн гэрэл тээвэрлэсэн байдал ба дагалдах хуудас*

## 11. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Ажлын гүйцэтгэл | Нийт зардал мян.төг | Биелэлтийн шалгуур |
|---|---|---|---|---|---|
| 1 | Байгаль орчны хууль, журмын хэрэгжилтийг хангах зорилгоор дотоод хяналтыг хэрэгжүүлэх | Паблик сервис ХХК | Сар бүр ажлын байрны үзлэгт хамрагдан ажиллаж байгаа бөгөөд 2024 оны хувьд ажлын байрны гүйцэтгэлийн биелэлтийн хувь 90% орчим байна. | Үйл ажиллагааны зардлаас | Үл тохирлуудыг 90% дээш арилгасан байх |
| 2 | Байгаль хамгаалах тэмдэглэлт өдрүүдэд сургалт, мэдээллийн ажил зохион байгуулах | Паблик сервис ХХК Нийт ажилтнууд | Ерөнхийлөгчийн үндэсний мод тарих өдөрт зориулан мод тарих талбайн шар өвсийг цэвэрлэх ажилд 1 машин 2 жолоочийн хамт оролцов. | 300’0 | |
| 3 | Цэций хорооллын СӨХ-ны ажлыг удирдан зохион байгуулах | Паблик сервис ХХК Нийт ажилтнууд | Өнгөлөг цэций СӨХ-ийг байгуулан Удирдах зөвлөлийн хурлыг зохион байгуулсан. | Үйл ажиллагааны зардлаас | |
| 4 | Хог хаягдлын менежментийн гүйцэтгэлийг захиалагч талд үнэлүүлж дүгнүүлэх; | Паблик сервис ХХК Нийт ажилтнууд | Сар бүрийн 1-ний өдөр гүйцэтгэлийн үнэлгээний тайланг захиалагч талд хүргүүлж сар бүрийн 3-ны өдөр дүгнэлтийн хуралд оролцож байна. | Үйл ажиллагааны зардлаас | Сар бүр дүгнүүлсэн байх |
| **БОМТ-ний зардал, мян.төг** | | | | **300’0** | |

### 11.1. Дотоод хяналт

Энержи ресурс ХХК-ын БОХАБЭАН-ийн албаны төлөвлөгөөт дотоод хяналт болон сар бүр тус албанаас ажлын байрны үзлэгийг хийдэг бөгөөд ажлын байрны үзлэгээр илэрсэн үл тохирлын биелэлтийн хувь 90% орчим байна.


"ПАБЛИК СЕРВИС" ХХКОМПАНИЙН ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН МОНИТОРИНГИЙН ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ҮЛ НИЙЦЭЛ, ЗӨВЛӨМЖ

2023.10.05

| Ажиглалт | Зөвлөмж |
|---|---|



*Зураг 11.2.1. Дотоод хяналт*

### 11.2. Үндэсний мод тарих өдөрт оролцов

Сумын төвийн "Хаан банкаас хойших" 1-р сургуулийн баруун талын төгсгөл хүртэлх талбайд 350 ширхэг хайлаас мод тарихаас гадна тарилтанд саад болж буй дотор талд ургасан хог ургамлыг цэвэрлэх ажилд 1 машин 1 жолоочийн хамтаар оролцов.



*Хог өвсийг цэвэрлэж буй байдал*

### 11.3. СӨХ байгуулах

Өнгөлөг Цэций Сууц Өмчлөгчдийн холбоо нь 2024 оны 6 дугаар сарын 24-ны өдөр бүртгүүлж гэрчилгээгээ авсан. Өнгөлөг Цэций СӨХ нь Удирдах зөвлөлийн 11 гүшүүн, хяналтын зөвлөлийн 3 гишүүн, гйцэтгэх захирал 1 гэсэн бүрэлдхүүнтэй ажиллаж байна.


















## 12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн нөлөөлөлд өртөж буй байгаль орчны дор дурдсан бүрдэл хэсгүүдийг заавал тусгаж, бүрдэл хэсэг тус бүрээр хяналт шинжилгээ хийх цэгийн байршил, хэмжилт, дээжлэлт авах үзүүлэлт, тоо, хугацаа, давтамж, зарцуулах зардал, хариуцан гүйцэтгэх этгээд, баримтлах стандарт, аргачлалыг нарийвчлан тусгана.” хэмээн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 1.6-д заасан байна. Үүний дагуу бид байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангийн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу энэхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулав.

БОМТ-г жил бүр шинэчлэн боловсруулж дараа оны эхэнд БОАЖЯ-аар батлуулж, оны эцэст тэдгээрийн биелэлтийг мөн БОАЖЯ-д тайлагнана.Хяналт-шинжилгээний дээж, сорьцыг МУ-ын болон гадаадын итгэмжлэгдсэн лабораториудад батлагдсан аргазүй, стандартын дагуу шинжлүүлнэ. Хяналт-шинжилгээний үр дүнг хянах үйл ажиллагааг хөндлөнгийнмэргэжлийн байгууллагуудаар, сум, багийн хөндлөнгийн хяналтын доор гүйцэтгүүлэх зэргээр оролцогч талуудын хяналтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй юм.

### 12.1. Хяналт шинжилгээ

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Ажлын гүйцэтгэл | Нийт зардал мян.төг | Биелэлтийн шалгуур |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хог хаягдлын дахиврын цэгийн орчмын хөрсний бохирдлыг хянах зорилгоор хүнд металлын шинжилгээ хийлгэх; | Хог хаягдлын цэг орчмын хөрс | Орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд хог хаягдлын орчмын цэгээс хөрсний микроэлементийн шинжилгээнд дээж авч ALS MINERALS итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийлгэсэн. | Захиалагч талын зардлаас | жилд 1 удаа |
| 2 | ПС ХХК-ийн үйл ажиллагаа явуулдаг ундны ус түгээх худгуудад усны ерөнхий химийн шинжилгээ хийлгэх | Ундны усны 3 худаг | Ундны усны 3 худаг дээр ерөнхий химийн шинжилгээг итгэмжлэгдсэн лабораторид хийлгэсэн. | 240.0 | Жилд 1 удаа |
| 3 | Хог хаягдлын цэг орчмын ургамлан бүрхэвчийн талхагдлыг хянах зорилгоор | Сайт орчим | Ухаахудаг уурхайн сайт орчмын ургамлын судалгаар мэргэжлийн | Захиалагч талын зардлаас | Жилд 1 удаа |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | ургамлын бичиглэл хийх; | | байгууллагаар хийлгэсэн. | | |
| 4 | Хог хаягдлын дахиврын цех орчмын агаарын бохирдлыг хянах зорилгоор мэргэжлийн байгууллагаар агаарын шинжилгээ хийлгэх; | Хог хаягдлын цэг | Гадаад орчны агаарын чанарын хяналт шинжилгээний хүрээнд бохирдуулагч хий болох азотын давхар исэл, хүхрийн давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл зэрэг хийнүүдийг итгэмжлэгдсэн “Ногоон титэм” лабораториор шинжүүлсэн болно. | Захиалагч талын зардлаас | Жилд 1 удаа |
| 5 | Хог хаягдлын цэг орчимд амьтны ажиглалтыг ажилчдын тусламжтайгаар тогтмол бүртгэх; | Хог хаягдлын цэг орчим | Тус ажил хийгдээгүй | - | Жилийн турш |
| Нийт | | | | 240.0 | |

### 12.1.1. Хөрсний микро элементийн шинжилгээ

Орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд хог хаягдлын орчмын цэгээс хөрсний микроэлементийн шинжилгээнд дээж авч ALS MINERALS итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээ хийлгэсэн.





Зураг 12.1.1.1. *Хөрсний микроэлементийн шинжилгээний дээж авч буй байдал*

Хүснэгт 12.3.2.1 *Хөрсний микроэлементийн шинжилгээний дүн, 2024 он*

| № | Байршил | Pb | Cd | Hg | As | Cr | Sr | V | Cu | Ni | Co | Zn | B |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | MNS 5850:2019 | 500 | 10 | 10 | 20 | 400 | 800 | 150 | 100 | 150 | 50 | 300 | 25 |
| 1 | Хогийн цэг | 8 | <0.5 | <1 | 11 | 18 | 130 | 36 | 21 | 15 | 7 | 44 | 40 |
| 2 | Харьцуулах цэг | 7 | <0.5 | <1 | 13 | 19 | 111 | 40 | 18 | 14 | 7 | 36 | 10 |

Шинжилгээний дүнгээс харахад элементийн агууламж MNS5850:2019 Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандартад заагдсан хэмжээнд байна.

**12.1.2. Усны чанарын хяналт**

Худгуудын усны шинжилгээг дотодын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн бөгөөд усны ерөнхий химийн шинжилгээ болон микробиологийн шинжилгээ нь ундны усны чанарын шаардлагыг хангаж байна.


УСНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ
Өмнөговь аймаг, Цогтцэций сум, "Ухаа Худаг" уурхай

СОРИЛТЫН ТАЙЛАН

№ 2024_15

Хэвлэсэн огноо: 2024.01.24
Хуудасны дугаар: 1/1

| Лабораторийн дугаар | Техникийн шаардлага | Сорьцын тодорхойлолт | Сорьц авсан аргачлал |
|---|---|---|---|
| 15/69-71 | MNS 0900:2018 | Унд ахуйн ус | MNS ISO 5667-5:2001 |

Сорьцын нэр:
1. 69 Сум, Баруун худаг
2. 70 Уурхайчин, 2-р худаг
3. 71 Уурхайчин, 2-р худаг

Сорьц авсан: Ус хангамжийн техникч

| Сорьцын хэмжээ | Сорьц авсан огноо | Шинжилсэн огноо |
|---|---|---|
| Тус бүр 2 литр | 2024.01.21 | 2024.01.21-2024.01.22 |

| Д/д | Шинжилгээний үзүүлэлт, нэгж | Шинжилгээний арын стандарт | Зөвшөөрөгдөх хэмжээ | Үр дүн 69 | Үр дүн 70 | Үр дүн 71 |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Өнгө, градус | MNS 1097:1970 | 20 | 0.0 | 0.0 | 0.0 |
| 2. | Цахилгаан дамжуулах чанар, мС/см | MNS ISO 7888:1999 | 1.0 | 1.19 | 1.10 | 1.10 |
| 3. | Уусмал давс, мг/л | - | | - | - | - |
| 4. | Усны орчин, pH | MNS ISO10523:2001 | 6.5-8.5 | 8.28 | 8.20 | 8.21 |
| 5. | Үлдэгдэл чөлөөт хлор (Cl2), мг/л | Фотометр D12B | 0.2-0.3 | ≤0.05 | ≤0.05 | ≤0.05 |
| 6. | Фторид (F-), мг/л | Фотометр D12B | 0.7-1.5 | 1.85 | 1.40 | 1.59 |
| 7. | Ерөнхий хатуулаг, мг-экв/л | MNS ISO 6059:2005 | 7.0 | 2.98 | 2.63 | 2.62 |
| 8. | Аммонийн ион (NH4+), мг/л | MNS 1097:1970 | 1.5 | 0.16 | 0.05 | 0.09 |
| 9. | Нитритийн ион (NO2-), мг/л | MNS 4431:2005 | 1.0 | ≤0.007 | ≤0.007 | ≤0.007 |
| 10. | Нийт төмөр (Fe), мг/л | MNS 4430:2005 | 0.3 | ≤0.05 | ≤0.05 | ≤0.05 |

Шинжилгээ гүйцэтгэсэн: Химич
Хянаж баталгаажуулсан: Чанарын менежер /Б. Алдарбаяр/

*Зураг 12.1.2. Усны ерөнхий химийн шинжилгээний дүн*

**12.1.2. 3 Хог хаягдлын цэг орчмын ургамлан бүрхэвчийн бичиглэл**

Ухаа худаг уурхай орчимд ургамалжилтын мониторингийн 5 цэгт бичиглэл хийж боловсруулахад Турьхан цэцэгт зурман сүүлт, Төлөгчдүү боролзот, Харлаг үмхий өвст, Таанат гэсэн 4 бүлгэмдэлд ялгарсан (Хүснэгт 2). Бүлгэмдэлд 18 зүйл хамрагдсанаас, фанерофит (P) ба криптофит (G) амьдралын хэлбэрүүд тус бүр нэг зүйл; гемокриптофит (H) 7 зүйл; терофит (T) 4 зүйл илэрсэн .

Хүснэгт 12.4.1.1.1 *Ухаа худаг уурхай орчмын ургамлын нөмрөгт бүлгэмдэл үүсгэлт, зүйлийн бүрэлдэхүүн*

| **Ухаа худаг уурхай** | | Наймантын хөндий | Нисэх буудал | Хулсангийн ус худаг | Хаягдлын далан | Шинэ усны худаг |
|---|---|---|---|---|---|---|
| Бичиглэлийн код | Амь драл ын хэлб | UHGSF01 | UHGSF 02 | UHGSF03 | UHGSF05 | UHGSF04 |
| Өндөршил (м) | | 1328.6 | 1388 | 1411.9 | 1453 | |

| **Ухаа худаг уурхай** | | | Наймантын хөндий | Нисэх буудал | Хулсангийн ус худаг | Хаягдлын далан | Шинэ усны худаг |
|---|---|---|---|---|---|---|---|
| Өргөрөг (N) | | эр (Raunkiaer, 1934) | 43.851820 | 43.770310 | 43.729920 | 43.65951 | 43.670330 |
| Уртраг (E) | | | 105.490500 | 105.576890 | 105.541950 | 105.59049 | 105.456560 |
| Өвслөг ташингын (Н) бүрхэц (%) | | | 25 | 30-аас 50 | 50-аас 75 | 25-аас 70 | 25-аас 70 |
| Зонхилогч зүйл (Н) | | | *P. tenuiflora* | *A. achilloides* | *P. nigellastrum* | *P. nigellastrum* | *A. polyrrhizum* |
| Зүйлийн тоо | | | 6 | 6 | 6 | 9 | 5 |
| **Зүйлийн шинжлэх ухааны нэр** | **Зүйлийн монгол нэр** | | | | | | |
| *Allium polyrhizum* Turcz. ex Regel | Таана, Багалгар сонгино | G | | 1 | | | 3 |
| *Puccinellia tenuiflora* (Griseb.) Scribn. & Merr. | Турьхан цэцэгт зурман сүүл | H | 2a | 2m | | 1 | 2a |
| *Ajania achilleoides* (Turcz). Poljak. | Төлөгчдүү бороолз | H | | 3 | | | |
| *Peganum nigellastrum* Bunge | Харлаг үмхий өвс | H | | | 2b | 2b | |
| *Anabasis brevifolia* C.A. Mey | Ахар навчит баглуур | H | | 1 | | | |
| *Convolvulus ammannii* Desr. | Амманы сэдэргэнэ | H | + | | | 1 | |
| *Oxybasis glauca* | Хөх ногоон лууль | T | | | 2a | | |
| *Allium mongolicum* Regel | Монгол сонгино, хөмөл | G | + | | | 1 | |
| *Echinops gmelinii* Turcz. | Гмелиний тайжийн жинс | H | | | | + | |
| *Lipschitzia divaricata* (Turcz.) Zaika, Sukhor. & N.Kilian | Дэрэвгэр хависхана | H | | | | + | |
| *Stipa glareosa* P.A.Smirn. | Сайрын хялгана | H | + | | | 1 | |
| *Artemisia xerophytica* Krasch. | Хуурайсаг шарилж | H | 1 | | | | |
| *Eragrostis minor* Host | Бага хургалж | T | | 1 | 2m | 1 | 1 |

| **Ухаа худаг уурхай** | | | Наймантын хөндий | Нисэх буудал | Хулсангийн ус худаг | Хаягдлын далан | Шинэ усны худаг |
|---|---|---|---|---|---|---|---|
| *Salsola tragus* L. | Өргөст бударгана | T | | + | + | 2b | 2a |
| *Kochia melanoptera* Bunge | Хар дэвүүрт тогторгоно | T | | | | 1 | |
| *Setaria viridis* | Ногоон хоног будаа | T | | | 1 | | |
| *Tribulus terrestris* | Зэл зангуу | T | | | 2m | | |
| *Neopallasia pectinata* | Шүлхий шарилж | T | | | | | 1 |

Товчилсон үгийн тайлбар: P: Фанерофит; Ch: Хамефит; G: Криптофит; H: Гемокриптофит; T: Терофит



Зураг 12.4.1.1.1. Уурхай орчмын ургамалжилтын ерөнхий төрх байдал





Зураг 12.4.1.1.2. *Ургамлын бичиглэл хийж буй байдал*

Зураг 12.4.1.1.2. *Ургамлын өндрийн хэмжилт*

### 12.2.3. Гадаад орчны агаарын чанарын хяналт шинжилгээ

Гадаад орчны агаарын чанарын хяналт шинжилгээний хүрээнд бохирдуулагч хий болох азотын давхар исэл, хүхрийн давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл зэрэг хийнүүдийг итгэмжлэгдсэн "Ногоон титэм" лабораториор шинжүүлсэн болно.

| Цэгийн нэр үзүүлэлт | Агаарын чанарын MNS4585:2016 стандарт | Хогийн цэг |
|---|---|---|
| Хүхэрлэг хий **SO2, мкг/м3** | 450 **мкг/м3** | 87.62 мкг/м3 |
| Азотын давхар исэл, **мкг/м3** | 200 **мкг/м3** | 55.21 мкг/м3 |
| Нүүрс төрөгчийн дутуу исэл, **мкг/м3** | 60 **мкг/м3** | <1ppm |
| Хүхэрт устөрөгч, **мкг/м3** | | |

*Зураг 12.1.3 Хэмжилтийн үр дүн*



## 13. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

| № | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах үйл ажиллагаа | Тайлан мэдээлэл хүлээн авах тал | Гүйцэтгэл | Биелэлтийн шалгуур |
|---|---|---|---|---|
| 1 | Багийн иргэдийн нийтийн хуралд оролцож мэдээлэл өгөх | Өгөөмөр баг | Өнгөлөг Цэций СӨХ-г байгуулж, холбооны удирдах зөвлөлийн 11 гишүүнээр дамжуулан багийн иргэдэд мэдээллийг өгч, хэрэглэгчдийн асуудлыг хүлээн авч ажиллаж байна. | Багийн нийтийн хурал зохион байгуулагдах үед |
| 2 | Холбогдох тайлан мэдээллийг төрийн захиргааны төв байгууллагад хүргэх | Өмнөговь аймгийн БОАЖГ | Компанийн БОННҮ-ний дагуу жил бүр БОМТ-г боловсруулж ажиллаж байна. Төлөвлөгөөний тайланг боловсруулж БОАЖЯ-ны мэдээллийн санд байршуулж. Бичгэн тайланг Өмнөговь аймгийн БОАЖГ-т өгөв. | Жилд 1 удаа |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3 | Хог хаягдлын статистик мэдээ | БОСШ | БОСШ-ний төвд Паблик Сервис ХХК нь тээвэрлэсэн, устгасан хог хаягдлын статистик тайланг гаргаж хүргэсэн. | Жилд 1 удаа |
| 4 | Сарын үйл ажиллагааны тайлан | Энержи Ресурс ХХК | Компанийн гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу сар бүрийн 1-ний өдөр үйл ажиллагааны тайлан болон гүйцэтгэлийн үнэлгээний тайланг бэлтгэн захиалагч талд цахимаар хүргэж, сар бүхийн 3-ны өдөр гэрээ дүгнэх хуралд оролцдог. | Сар бүр |

## 13.1. Иргэдэд мэдээ, мэдээлэл өгөх

Паблик сервис ХХК нь үйл ажиллагааны мэдээллийг сууц өмчлөгчдийн холбоо, түүний удирдах зөвлөлөөр дамжуулан иргэдэд өгч ажиллаж байгаа бөгөөд Өнгөлөг Цэций Сууц Өмчлөгчдийн холбоо нь 2024 оны 6 дугаар сарын 24-ны өдөр бүртгүүлж гэрчилгээгээ авсан. Өнгөлөг Цэций СӨХ нь Удирдах зөвлөлийн 11 гүшүүн, хяналтын зөвлөлийн 3 гишүүн, гйцэтгэх захирал 1 гэсэн бүрэлдхүүнтэй ажиллаж байна. Тус бүрэлдэхүүн үүсгэн байгуулагдсанаас хойш 3 удаагийн хурлыг зохион байгуулсан байна.


СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБОО

ГЭРЧИЛГЭЭ

ДУГААР 2024/01

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Цэций хороолол байрлалтай Сууц өмчлөгчдийн хурлын шийдвэр, холбооны дүрэм, удирдах зөвлөлийн албан хүсэлт -ийн өргөдөл, холбогдох бичиг баримтыг хянан үзээд "Өнгөлөг Цэций" Сууц өмчлөгчдийн холбоо -г

(сууц өмчлөгчдийн холбооны нэр)

Монгол Улсын Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтыг үндэслэн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын "СУУЦ ӨМЧЛӨГЧДИЙН ХОЛБОО"-ны бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгов.

ЗАСАГ ДАРГА Г.БАЦМАА

2024 он 06 сар 24 өдөр
















Мэдээлэл өгч ажилласан байдал

### 13.2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайлан

Компанийн БОННҮ-ний дагуу жил бүр БОМТ-г боловсруулж ажиллаж байна. Төлөвлөгөөний тайланг боловсруулж БОАЖЯ-ны мэдээллийн санд байршуулж. Бичгэн тайланг Өмнөговь аймгийн БОАЖГ-т өгөв.

2024 оны БОМТ-г хянасан болон баталсан QR

## 14. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТӨСВИЙН ЗАДАРГАА

| № | Хийгдэх ажлын чиглэл | Хийгдсэн ажлын тодорхойлолт | Зарцуулалт, мян.төг |
|---|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв | Хариу арга хэмжээ | 1’300.0 |
| 2 | Нөхөн сэргээлт | Мод сөөг тарьж ургуулах<br>Мод сөөг үржүүлэх, ногоон байгууламжийн усалгаа арчилгаа, мод тарих | 600.0 |
| 3 | Дүйцүүлэн хамгаалах үйл ажиллагаа | Өвс тэжээл | 500.0 |
| 4 | Нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор | Өвс тэжээл | 900.0 |
| 5 | Түүх соёлын өвийг хамгаалах | Ажил төлөвлөгдөөгүй | - |
| 6 | Осол эрсдэлийн менежмент | | - |
| 7 | Хог хаягдлын менежмент | Хог хаягдлын ангилан ялгалтын нэр төрлийг нэмэгдүүлэх, хог хаягдал түр хадгалах цэгийг сайжруулах, | 500.0 |
| 8 | Удирдлага зохион байгуулалт | Сургалт | 300.0 |
| 9 | Орчны хяналт шинжилгээ | Усны хяналт шинжилгээ<br>Агаарын чанарын хяналт шинжилгээ<br>Хөрсний хяналт шинжилгээ | 240.0 |
| 10 | Олон нийтэд тайлагнах | Мониторингийн ажилд олон нийтийг оролцуулах, төрийн байгууллагад мэдээ тайлан хүргүүлэх | - |
| | НИЙТ ЗАРДАЛ, мян.төг | | 4,340.0 |